



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ СУРГУУЛЬ



ОЛОН УЛСЫН
ХАРИЛЦАА

WORLD AFFAIRS

2007 №1 289 (14)



Улаанбаатар хот

Тус сэтгүүл нь анх 1996 оноос “Алтан аргамж” нэрээр, 2002 оноос “Олон улсын харилцаа” нэрээр гарч байна.

The journal has been published since 1996 as “Altan argamj” and since 2002 as “World Affairs”

Сэтгүүлийн зовлол:

Эрхлэгч:

Н.Алтанцэцэг (тэр.проф.доктор Ph.D)

Нарийн бичгийн дарга:

Д.Тунгалаг (проф.доктор Ph.D)

Гишүүд:

Ж.Баясах (тэр.проф.доктор Sc.D)
Ц.Гурбадам (проф.доктор Sc.D)
Д.Цолмон (тэр.проф.доктор Ph.D)
Б.Хулдорж (проф.доктор Ph.D)
Д.Намсрай (дэд проф.доктор Ph.D)
Д.Отгончимэг (дэд проф.доктор Ph.D)
Б.Энхбаяр (проф.доктор Ph.D)
Ж.Баттогтох (доктор Ph.D)

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

С.Оюунсүрэн

Сэтгүүлийн хаяг:

МУИС-ийн Олон улсын
харилцааны сургууль
Шуудангийн салбар – 46 а, хайрцаг-6
Улаанбаатар, Монгол улс
Утас: 354610; 354611; 354618
Факс: (976-11)354610
E-mail: muis_sfs@yahoo.com

Editorial Board:

Editor inChief:

N.Altantsetseg (Prof.Ph.D)

Editor:

D.Tungalag (Prof.Ph.D)

Members:

J.Bayasakh (Prof. Sc.D)
Ts.Gurbadam (Prof. Sc.D)
D.Tsolmon (Prof.Ph.D)
B.Khuldorj (Prof.Ph.D)
D.Namsrai (Prof.Ph.D)
D.Otgonchimeg (Prof.Ph.D)
B.Ehkhbayar (Prof.Ph.D)
J.Battogtokh (Ph.D)

Assistant:

S.Oyunsuren

Editorial Address:

School of Foreign Service
National University of Mongolia
P.O. – 46 а, Box-6
Ulaanbaatar, Mongolia
Tel: 354610; 354611; 354618
Fax: (976-11)354610
E-mail: muis_sfs@yahoo.com

АГУУЛГА

I. Монгол улсын Дипломат алба үүсэн байгуулагдсаны 95 жил, ууган дипломатч, Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд агсан М. Дүгэрсүрэнгийн мэндэлсний 85 насны ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүд

Х. Бэхбат	5
ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын хэлсэн үг.....	
Ц. Гомбосүрэн	8
Монгол улсын гадаад харилцаа: шинэ чиглэл, шинэ түншүүд.....	
Ч. Очирбат	19
Монгол улсын гадаад эдийн засгийн харилцааны шинэ номлолын үндэс.....	
Б. Должинцэрэн	30
М. Дүгэрсүрэн ба БНМАУ-ын Ази, НУБ-ын талаарх бодлого.....	
Г. Төмөрчулуун	34
Бага, жижиг улсын гадаад бодлогыг хэрэгжүүлэхэд дипломат ажиллагааны үүрэг.....	
Л. Эрдэнэчулуун	42
Миний ажил, амьдралын гараа М. Дүгэрсүрэн сайдтай салшгүй холбоотой.....	
Д. Цолмон	53
Үндэсний эрх ашиг, улс орны нэр төрийг хамгаалахад дипломатуудын үүрэг хариуцлага.....	
Н. Алтанцэцэг	60
Гадаад албаны ажилтан бэлтгэх анхны төрийн сургууль-МУИС-ийн ОУХС-ийг үүсгэн хөгжүүлэхэд М. Дүгэрсүрэнгийн гаргасан хичээл зүтгэл, оруулсан хувь нэмэр.....	
Удо Б. Баркманн	75
Өнөөгийн Монгол улсын гадаад бодлогын талаарх Германы нэгэн монгол судлаачийн сэтгэгдэл	
Ш. Бира	80
Дурсамж	
З. Эрэндөө	83
Дүүгээ сайдаа дурсахуй	

II. Монгол улсын гадаад бодлого, олон улсын харилцаа

Н. Алтанцэцэг	88
Орчин үеийн дипломат ажиллагаанд гарч буй шинэ хандлага, өөрчлөлтүүдийг Монгол улсын дипломат ажиллагаанд тусгах нь.....	
Ц. Гүрбадам	100
Умард, Өмнөд солонгосчуудын нэгдэх нь XXI зууны түүхэн том үйл явдал болно	
Г. Баасанхүү	116
Гадаад бодлого ба олон улсын харилцааны харилцан хамаарал	

III. Олон улсын эдийн засгийн харилцаа

Д.Тунгалаг	127
Дэлхийн хотжилт, хүн амын бодлогын асуудалд	

IV. Түүх, соёл иргэншил

Ж. Баясах	132
Оросын түүх, соёл иргэншил	

Сургуулийн гадаад харилцааны үйл явдлаас.....	145
---	-----

МОНГОЛ УЛСЫН ДИПЛОМАТ АЛБА ҮҮСЭН
БАЙГУУЛАГДСАНЫ 95 ЖИЛ, УУГАН
ДИПЛОМАТЧ, ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ
ЭЛЧИН САЙД АГСАН М.ДҮГЭРСҮРЭНГИЙН
МЭНДЭЛСНИЙ 85 НАСНЫ ОЙД ЗОРИУЛСАН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН
ИЛТГЭЛҮҮД

ГХЯ-НЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Х. БЭХБАТЫН ХЭЛСЭН ҮГ

Х. Бэхбат*

Монгол улсын төрийн зүтгэлтэн, Гадаад явдлын яамны сайд агсан, нэрт дипломат, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мангалын Дүгэрсүрэнгийн мэндэлсний 85 насны ой энэ өдрүүдэд тохиож байна.

М. Дүгэрсүрэн бол орчин цагийн Монголын мэргэжлийн анхны дипломатуудын нэг, эх орныхоо дипломат албанд хоёргүй сэтгэлээр насан эцэслэлтээ зүтгэж явсан, Монгол улсынхаа гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулсан нэрт дипломат байсныг тэмдэглэхэд таатай байна.

Гадаад яамны түүхэнд Гадаад хэргийн жинхэнэ сайдаар нийт 17 жил буюу хамгийн олон жил ажилласан хүн бол М. Дүгэрсүрэн юм. ГЯЯ-ны сайдаар хоёр удаа томилогдон ажилласнаас гадна орлогч сайд, БНЭУ-д Элчин сайд, Нью-Йорк, Женевт НҮБ, Зэвсэг хураах бага хуралд Байнгын төлөөлөгчөөр ажиллаж байсан. Энэ бүх өндөр, хариуцлагатай албыг ээлж дараалан хашихдаа эх орныхоо тусгаар тогтнолыг бататгах, олон улсын байр суурийг бэхжүүлэх, гадаад харилцааг өргөжүүлэхэд бүхий л авьяас чадвар, мэдлэг боловсрол, хүч чармайлтаа бүрэн дайчлан зориулж байсан юм. Тэрээр тухайн үеийнхээ нам, төрийн гадаад бодлогыг боловсруулах, төлөвлөх, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх процесс, механизмыг боловсронгуй болгоход дорвитой хувь нэмэр оруулсны зэрэгцээ ГХЯ, Монголын дипломат албыг бэхжүүлэх, мэргэжлийн боловсон хүчнээр хангах, тэдний бүхэл бүтэн үеийг сурган төлөвшүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн гэж үзэж болно.

М. Дүгэрсүрэн НҮБ, түүний системийн болон олон улсын бусад байгууллагад улс орныхоо нэр хүнд, байр суурийг өсгөн бэхжүүлэхэд онцгойлон анхаарч байсан бэгөөд өөрөө ч олон улсын хэмжээнд жин дарж хүндэтгэл хүлээдэг дипломат байсан юм. Олон

* Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, ГХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга

улсын харилцааны хувьсал өөрчлөлт, тодорхой улс гүрний гадаад бодлогын онцлогийг соргоогоор тусган дүн шинжилгээ хийх чадвар, туршлагаар арвин, аливаа ажилд туйлын няхуур, нямбай ханддаг, зарчимч, ажилсаг, төрийн ажлын өндөр соёлтой нэгэн байжээ. Түүний сайд байсан үеийн сүүлчээр буюу 1980-аад оны байдлаар манай улс 100 гаруй улстай дипломат харилцаатай болж, олон арван улстай худалдаа, эдийн засаг, соёлын талаар хамтран ажилладаг, дэлхийн дэвжээнд нэрийн данстай орон болоод байсан нь эсрэг тэсрэг хоёр системийн зөрчил дунд нэг талыг барьсан, ангич, намч үзэл суртлаар гадаад бодлого нь тодорхойлогдож байсан манайх шиг жижиг улсын хувьд томоохон ололт байлаа. Энэ ололт М. Дүгэрсүрэн сайд, түүний олон жил толгойлсон дипломат албаны үйл ажиллагаатай салшгүй холбоотой. Тийм ч учраас түүний ажил үйлс, гавъяа зүтгэлийг Монголын төр, засаг удаа дараа өндрөөр үнэлж байсан билээ.

М. Дүгэрсүрэн сайд гавъяаныхаа амралтанд гарсан ч гадаад харилцааны салбар, гаршсан мэргэжилдээ үнэнчээр үлдсэн юм. МУИС-ийн ОУХС-д зөвлөх байхдаа тус сургуулийг хөл дээр нь босгох, хөгжүүлэхэд хувь нэмрээ хандивлаж, сурах бичиг зохион хэвлүүлэх, заах арга зүйгээр хангах, гадаадын ижил төрлийн сургуулиудтай холбоо тогтоох зэргээр идэвхтэй хамтран ажиллаж байлаа. М. Дүгэрсүрэн, О. Хосбаяр нарын туурвисан “Олон улсын эрх зүй” нэг сэдэвт бүтээл, бусад бүтээл нь өнөө ч ач холбогдлоо алдаагүй олон зуун оюутны ширээний ном болсоор байна.

Аливаа хувь хүн, түүхэн хүний ойг тэмдэглэх асуудал түүний намтар судлалтай шууд холбоотой. Эрдэмтэн мэргэдийн нэг хэсэг нь “хүн бол түүхэн цаг үеийнхээ бүтээгдэхүүн мөн” гэдэг бол нөгөө хэсэг нь “хүний төрөлхийн зан чанар ямар байна, тийм л хувь зохиолтой байна” гэцгээдэг. Аль аль нь зөв боловч чухам үнэн нь тэг дунд нь байдаг гэж бас нэг хэсэг нь мэтгэх буй заа.

М. Дүгэрсүрэн сайдын “өв” буюу “наслед”-ыг тал бүрээс нь судалж, танин мэдэх шаардлагатай гэж би хувьдаа үздэг юм. Түүнийг төрийн зүтгэлтнийх нь хувьд, Монгол улсын гадаад бодлого, дипломат албаны гарамгай төлөөлөгч, нэрт дипломатынх нь хувьд гүнзгий судалж, нийтийн хүртээл болгох нь өнгөрсөн 20 дугаар зууны хоёрдугаар хагасын Монголын түүхийг туурвих, Монгол төрийн туурга тусгаар, бие даасан байдлын төлөө үе үеийнхний тэмцлийн түүхийг мөнхлөхөд ач тустай үйлс болно гэдэгт эргэлзэхгүй байна.

М. Дүгэрсүрэн агсны тэмдэглэлт ойн жил, түүний гэгээн дурсгалд зориулан хийж байгаа “Гадаад харилцааны мэдлэгийн суурийг бэхжүүлэх нь” сэдэвт өнөөдрийн энэ бага

хурал нэн ялангуяа манай өсвөр үе, оюутан залууст нэгэн тод үлгэр дууриал үзүүлж, тэдний эх оронч сэтгэлгээ, гадаад бодлогын сэтгэлгээг хөгжүүлэхэд чухал арга хэмжээ болно гэж итгэж байна. Бага хурлыг зохион байгуулах санаачилга гаргаж, сэтгэл, зүтгэл нийлэн ажиллаж буй ОУХС-ийн удирдлага, М. Дүгэрсүрэн сайдын гэр бүлийн гишүүд, нийт оролцогчид ГХЯ-ны удирдлага, хамт олны нэрийн өмнөөс талархал илэрхийлье.

“Дүгэрсүрэн судлал”-ын гараа эхэлж байх шиг байна. Аян зам нь өлзийтэй байх болтугай.

Бага хурлын ажиллагаанд амжилт хүсье.